

I-III/2021


Тархаасан: 2021 оны 4 дүгээр сарын 14



Цагаан ноолуурын 1 кг-ын үнэ Дорнод аймагт хамгийн их буюу 155.0 мянган төгрөг байна.


Малын зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2021 оны 3 дугаар сард ат 1.1 сая төгрөг, хязаалан гуна 1.0 сая төгрөг болж, өмнөх сараас тус тус өөрчлөлтгүй, соёолон үрээ 849.8 мянган төгрөг болж, өмнөх сараас 54.4 мянган төгрөгөөр буурсан. Харин эр хонь 173.5 мянган төгрөг болж, өмнөх сараас 7.9 мянган төгрөгөөр, эр ямаа 124.9 мянган төгрөг болж, өмнөх сараас 4.1 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

Зураг 1. Нас гүйцсэн малын дундаж үнэ, 3 дугаар сард, мянган төгрөгөөр




Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2021 оны 3 дугаар сард цагаан ноолуурын 1-кг-ын дундаж үнэ Дорнод аймагт хамгийн их буюу 155.0 мянган төгрөг, Дундговь аймагт хамгийн бага буюу 70.0 мянган төгрөг байна.

Зураг 2. Цагаан ноолуурын 1 кг-ын дундаж үнэ, 2021 оны 3 дугаар сард, төгрөгөөр




Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2021 оны 3 дугаар сард үхрийн 2 метрээс дээш урттай шир 5.6 мянган төгрөг болж, өмнөх сараас 2.5 мянган төгрөгөөр буурсан байна. Харин ямааны цагаан ноолуур 1 кг-ын үнэ 114.3 мянган төгрөг болж өмнөх сараас 55.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Зураг 3. Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ, жил бүрийн 3 дугаар сард, төгрөг



Газар тариалангийн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2021 оны 3 дугаар сард боодолтой (20кг) өвсний үнэ Баян-Өлгий аймагт хамгийн их буюу 13.5 мянган төгрөг болж, өмнөх сараас 500 төгрөгөөр өсөж, Дорнод аймагт хамгийн бага буюу 4.0 мянган төгрөг болж, өмнөх сараас 1.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Зураг 4. Боодолтой өвсний дундаж үнэ, 2021 оны 3 дугаар сард, төгрөгөөр



Газар тариалангийн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2021 оны 3 дугаар сард 25кг хивгийн үнэ Баян-Өлгий аймагт хамгийн их буюу 26.0 мянган төгрөг болж, өмнөх сараас 5.0 мянган төгрөгөөр өсөж, харин Дархан-Уул аймагт хамгийн бага буюу 13.2 мянган төгрөг болж, өмнөх сараас өөрчлөлтгүй байна.

**Тооцох аргачлал:**

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн судалгааг сар бүр, сум, дүүрэг, аймаг, нийслэлийн худалдааны цэгүүдээс авч нэгтгэн сарын дундаж үнийг арифметик дунджаар тооцно.

**Эх үүсвэр:** ҮСХ, ХАА-н бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээ



**Мэдээлэл авах линкүүд:**

<http://www.nso.mn/>  
<http://www.1212.mn/>

**Дараагийн мэдээ тархаах хуваарь:** 2021 оны 5 дугаар сарын 17

*Эдийн засгийн статистикийн газрын  
дарга Э.Эрдэнэсан  
Утас : (976-51)-266414*

*Эдийн засгийн статистикийн газрын  
Гэрээт ажилтан Б. Оргил  
Утас : (976-51)-261561*

